

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Д.Цэцэгмаа, Бархүү	Дугаар	L243
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Мандал-Овоо сум
Төрсөн газар	Мандал-Овоо сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хошуу хурал	Сүм хийдийн дугаар	ӨГМО 001
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Хошууны хурал

Гантулга: Онгийн гурван хийдийн нэг болох Хошууны хурлын хувраг агсан Жанги овогтой Халтарын Дамдинсүрэн гэдэг хүний ар гэр хань болох Бархүү мөн, түүний охин Цэцэгмаа нартай ярилцлага хийх гэж байна. За энэ Хошууны сүм хийдийн тухай товч мэдээлэл өгнө үү.

Цэцэгмаа: За Хошуу хийдийн тухай одоо манай эцэг нэлээд ярьдаг хүн байсан. Эцэг маань одоо өөрөө 7 настай тэнд суугаад 10 жил болсон юм гэнэ лээ. За Хошуу хийдийг одоо их сайхан газар байсан, олон лам хуврагтай энэ хошуу нутагтаа хүндлэгдсэн ийм хийд байсан гэж эцэг минь ярьдаг байсан. За Хошуу хийд нь одоо манай эцэг 7 настай очиж суусан гэж ярьдаг, тэр үед их олон ламтай байсан юм гэнэ лээ. За лав л тэр Майдар бурхан бүтээж байсан тухай их ярьдаг байсан юм. Өөр би одоо тэр хийдэд нь ороод сууж байхад л омог нь хавьгүй том тээр тэнд харагдаж байсан гэж ярьдаг. Тэгэхээр одоо найм есөн настайдаа байсан юмуу, эсвэл тэр арван хэдтэй байсан юм уу тэгж ярьдаг байсан юм. За тэгээд олон дугантай, олон жастай, ийм хурлын газартай гээд мөн ч их сайхан байсан олон түмэн их сүсэг бишрэлтэй ийм байсан гэж их ярьдаг байлаа. За би ч одоо тэгээд дуулсан

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

мэдсэнээ ярьлаа. Бархүү:Манай бурхан болооч болвол багаасаа жоохноосоо эрвээхий юу их тоглодог хүүхэд байсан юм. Тэр сүүлд бол хохь бас их тоглодог байсан гэсэн.Тийм , их тоглодог байсан гэсэн

Гантулга: Эрвээхий гэдэг чинь?

Бархүү: Тийм, тэр дөрвөн эрвээхийг...

Цэцэгмаа:Тэр цамд л ордог байсан бүжиг...

Гантулга: Хохь гэдэг нь?

Бархүү:Хохь гэдэг нь бас сэвгүй цагаан тийм...

Гантулга: Цамын л багнууд юм байна ш дээ.

Бархүү:Тийм.Тэрийг нь л дутаагаад л тэгээд байдаг байсан.Тэр өвгөн л тэгээд тэр цагаан юмыг өмсөөд тэр хүмүүс чинь хохьд тоглоод...Тэгэд модоор хатгаж бариад хойш нь ухраадаг байсан юм байна.Тэгээд тэр хүмүүс чинь айгаад хойшоо амархан ухарнаа

Гантулга: Ер нь өөрөөр юу гэж дууддаг байсан юм?

Бархүү:Ерөөсөө Хошуу хийд л гэнэ

Гантулга: Аан за за.

Бархүү:Ерөөсөө Хошуу хийд , Хошуу хийдний л чуулган гэнэ

Гантулга: Байгуулагдсан оныг нь мэдэх үү , та?

Бархүү:Аа мэдэхгүй

Цэцэгмаа: За ижий маань бол тэр Энх Амгалан хааны үед 1840-өөд оны үед байгуулагдсан юм гэнэ лээ гэж ярьдаг байсан .Онгийн гурван том хийдийн нэг байсан юм гэнэ лээ .Ер нь , Барин хамба ламын хийд , Хутагт ламын хийд , Онгийн Хошууны хийд гэж ийм гурван том хийд байсан.Тэр гурван хийдээс хамгийн том нь энэ Хошуу хийд гэж. Одоо олон хошуунаас банди нар ирж суудаг , цугладаг байсан учраас Хошуу гэж нэр авсан юм билээ гэж ярьдаг байсан.Ер нь тэр анх нөгөө Барин лам, Хутагт лам нар нь анх үүсгэн байгуулсан юм болов уу гэж би нэг ойлгосон юм. Тэр удирддаг байсан юм гэж ярьдаг юм

Гантулга: Анх байгуулсан хүнийх нь нэр?

Бархүү: Мэдэхгүй ээ, байгуулсан хүний нэрийг нь мэдэхгүй

Гантулга: Одоо энд тэндхийн сүм хийдийн лам нар ирж ном хаялцдаг ч юмуу, холбоо харилцааных нь тухай юм ярьж байсан уу, ойролцоо сүм хийдийнх нь хурлын тухай?

Цэцэгмаа: Тэр хурал ном ирж, ном хаялцдаг байсныг нь би сайн мэдэхгүй байна.Тий лам ирж тэгж ном хаялцаж байсан юм гэнэ лээ, ийм лам ирж ингэж ном хаялцаж байсан юм гэнэ лээ, хаялцаж байсан гэж тэр Цагаан Бандгай , Бор Бандгайгэж улсууд ярьдаг байсан л даа.Цагаан Бандгай гэдэг нь Банзрагч гэж хүн байлаа. Бор Бандгай гэдэг нь Лувсан гэж хүн байсан юм. Тэр улсууд тэгж тийм лам нар ирж ном хаялцдаг байсан гэж ярьдаг байсан. Тэр хоёр лам нь энэ Хошуу хийдийн лам нар байсан.

Гантулга: Аа мөн, Монголын ямар ямар сүм хийдүүдтэй уг сүм хийд нь харилцаа холбоотой басйан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэцэгмаа: Ер нь ийш тийшээ их явж эргэл мөргөл хийдэг байсан гэж ярьдаг байсан шүү. Лав л Эрдэнэ Зуу хийд дээр очдог байсан гэсэн. Тэгээд энэ зүүн...

Бархүү:Ламын хийд, Эрдэнэ Зуу. Тэгээд энд Шар хулсны гэж бас хөөрхөн хийд байсан юм. Тийм манай энэ хэд бол сайн мэднэ

Цэцэгмаа: Тэр Хамрын хийдээс лам нар ирж, Хамрын хийд гэдэг билүү...Тэндээс одоо лам ирж бас ном хаялцдаг байсан гэж ярьдаг байсан шүү

Гантулга: Төвдийн одоо ямар ямар сүм хийдүүд уг сүм хийдтэй харилцаа холбоотой байсан бэ?

Бархүү:Энэ Шар хулс лав байсан.

Цэцэгмаа: Тэр Төвдийн лам нараас ер нь нааш цаашаа ирдэг улсууд их байсан гэдэг дээ. Ээж ер нь мэдэх үү?

Бархүү:Мэднэ. Харин Даарамба ламыг мэдн. Даарамба лам гэж онцгой том лам байсан.Их цуутай...

Гантулга: Тэр Төвд хүн байсан уу?

Бархүү: Төвд хүн байсан.Жинхэнэ Төвд хүн байсан юм

Цэцэгмаа: Тийм , тэгээд тэр хүнд их очиж мөргөдөг байсан юм

Бархүү:Манай багш байсан юм. Тэгээд тэр Даарамба багшийн шавь байсан. Миний эцгийн багш байгаа юм.Тэгээд энд цөөхөн хийд байсан , бас олон ламтай.Эндээ цөөхөн, тэгээд тогшвол хүрэхгүй л дээ, зүгээр.

Гантулга:Аа энэ сүм хийд нь одоо аль урсгалын сүм хийд байсан бэ?Шарын шашных юмуу, улааных юмуу?

Цэцэгмаа: Шарынх шарынх, ер нь дандаа шарын шашных байсан.Харин тэр Ламын хийд энэ тэр чинь улааных байсан юм гэнэ шүү.Тийм, тэгж нэг дуулдсан

Гантулга: Энд одоо хэдэн хийд , хэдэн хуваргатай байсан бэ?

Цэцэгмаа: Тоог нь мэдэхгүй л дээ, ер нь гайгүй олон ...Найман зуу, бараг мянга гаруй л хүн байдаг гэж ярьдаг байсан.Одоо нөгөө Мандал овоо, Цогт овоо, Цогт цэций , Ханхонгор, Булган сумаас л бүх л хүмүүс нь ирж энд одоо суудаг, шавилж суудаг.Ийм л байсан юм гэнэ лээ.

Гантулга: Өдөр тутмын ямар хурал хурдаг , аа мөн дүйчэн өдрүүдээр ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Бархүү:Дүйчэн өдрүүдээр дандаа буян хийнэ.Хэнд чиг л байсан том ном уншдаг байсан. Ерөөсөө нойр хоолгүй л тэр шөнө ном уншдаг байсан шүү дээ.Тэр дүйчэн шөнөөр чинь нойргүй хонодог тийм уншлагатай байсан.Хошуу хийд ч тийм байсан, тэр Шар хулс ч тийм байсан

Гантулга: Дүйчэн өдрөөр болон шинийн найманд...?

Бархүү:Шинийн найман, арван таванд

Гантулга: Арван таван , хорин есөнд?

Бархүү:Хорин..., битүүн

Гантулга: Гучин битүүнд...?

Бархүү:Тийм , битүүний хурал гэж байсан даа.

Гантулга: Цагаан сарын хурал гэж байсан уу?

Бархүү:Өө цагаан сараар чинь нойргүй хурна.Тийм жигтэйхэн хурна

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тухайн сүм хийдийн лам нар нь хаагуураа амьдардаг байсан бэ?

Бархүү: Үгүй ээ энэ манай Хошуу хийдийнх үү?

Цэцэгмаа: Тийм , энэ гэр нь хаагуураа байдаг байсан юм бол?

Бархүү:Яг л тэр манай Хошууны хийдийн тэнд, гэр нь хийдтэйгээ.Гэхдээ хөдөөний баян айл байсан, манай өвгөнийх чинь .Ах ламынх нь ч бас л бүгдээрэ гэр оронтой...

Гантулга: Танай ах лам чинь одоо юу , ямар мяндаг цолтой хүн байсан бэ?

Бархүү:Тэр гавж..., тэгээд гэсгүй

Гантулга: Тэгээд хэн гэж хүн байсан юм бэ?

Цэцэгмаа: Ишданзан гэж хүн байсан юм

Гантулга: Овог нь ?

Цэцэгмаа:Овог нь Цэдэндорж гэдэг байсан .

Гантулга: Цэдэндоржийн Ишданзан гэж хүн байж. Сүм хийдийн жасын тухай та яриач?

Цэцэгмаа: За тэр ч одоо мэдэхгүй юм аа

Гантулга: Дуулсан юм байвал л гэж байгаа юм. Хичнээн жас малтай байсан, энэ талаар?

Цэцэгмаа: Сайн мэдэхгүй юм даа.

Гантулга: Ер ньхүмүүс сүм хийдэд ямар үед ирдэг байсан юм бол, ямар ямар зан үйл хийдэг байсан юм бол, эргэл мөргөл юмуу, ном тавих ч юмуу, цам гарах ч юм уу, сор залах ч юмуу, энэ тухай?

Цэцэгмаа:Хачин их хийдэг байсан юм. Хүмүүс ч их ирдэг байсан.Майдар байсан...Сорд очно, сор залах ёслол хамгийн том нь .Майдарт очно.Тийм, сор бас болно. Одоогийнхоор бол наадам юм уу даа/инээв/

Гантулга: Тэгээд тэнд үзсэн харснаа жаахан дэлгэрүүлээд яривал?

Цэцэгмаа:Тэрэн дээр чинь үзсэн харсан сонин юм яривал их бий. Чам гээд өнөөх хорин нэгэн дарь эх сууж байдаг байсан. Хорин нэгэн дарь эх гээд нөгөө хоорондоо жигтэйхэн адилхан, их адилхан нэг хүн шиг л хорин нэгэн хүн сууж байдагсан.Тэгээд л дарь эхэд их мөргөнө өө.Сор залах жигтэйхэн их юм бий.Тэгээд цамд мөргөнө. цам эргэнэ. Чойжоо бас эргэх гэж...

Гантулга:Чойжоо гардаг...?

Цэцэгмаа: Чойжоо гарна. Тэгээд тэр чинь туйлын үнэтэй, хүндтэй мөргөл байлаа

Гантулга:Тухайн сүм хийдийн хутагт хувилгаан лам хуваргын тухай ямар нэгэн аман түүх мэдэх эсэхээсээ ярьж өгөөч?

Цэцэгмаа: Сайн мэдэхгүй юм байна ш дээ.Ах ламынхаа тухай л ганц ярьж мэдэх юм.Тэгээд одоо...

Гантулга: Дорамба?

Цэцэгмаа: Дорамба- Хошуу хийдийн лам, биш ээ, Шар хулсын лам

Гантулга: Аан Шар хулсын лам уу?

Цэцэгмаа: Тийм, ах ламаасаа бага сага мэднэ. Тэгэд хорин есөн онд л цагдаад явсан даа.

Гантулга: Сүм хийдээс одоо тахилгат газар тахидаг байсан тухай .Ойрын тахилгатай уул усны талаар?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэцэгмаа: Овоо мовоо тахидаг байсан. Овоо тахиад морь уралдуулна.Одоо манай энэ Цагаан Овоо, Амгалан овоо энэ тэрийг...

Гантулга: Мандал Овоо юу?

Цэцэгмаа: Тэрийг чинь сайн мэдэхгүй юм аа.Тиймээ, тийм Цагаан Овоо чинь , Амгалан овоо...

Гантулга: Тэрийгээ Мандал овоо гэдэг юм уу, Цагаан Овоог чинь хоёр янзаар нэрлэдэг байсан юм уу?

Цэцэгмаа:Тийм юм даа. Энэ Цагаан Овоо чинь Амгалан Овоо юм.Мандал гэдэг толгой байсан .Өмнө нь Цагаан овоо гэж байдаг.Чулуу босгоод Мандал Овоо болсон.Одоо Мандал баг ч гэж байгаа. Тэрийг ер нь олон жил тахидаг байсан.Сүүлд ерээд оноос ахиж тахидаг болсон. Ийм л овоо доо.Бүр бараг нураачихсан байсийм, ахиж сэргээж бариад овоо гэгчийн хадаг яндартай тийм овоо бий. Дээр үед олон жил тахисан, ерөөс л манай сумын ганц тахилгын овоо нь байсан юм гэнэ лээ.Зөвхөн цагаан идээгээр л тахидаг, шүүс үзүүлдэггүй.Харин урдах тэр Цагаан овоог бол шүүсээр тахидаг байсан.Ийм хоёр овоо л доо. Ер нь ойролцоо л доо .Бие биенийгээ харсан. Тэгээд олон лам нар ирж тахидаг байсан .Чухам Хошуу хийдээс ирдэг байсан юм уу, ямар чиг л байсан тэд нараас ирэх нь мэдээж. Бид бол яахав ерээд оноос хойшхийг сайн мэднэ ээ. Нэлээд хэдэн жил тахисан юм.

Гантулга: Сүм хийд хаагдсан, нураагдсан тухай ? Хэдийд хаагдсан, хэдийд нураагдсан тэр он?

Цэцэгмаа: 38, 39 онд л ерөөсөө бар жилд л байх.Тэгээд л ерөөсөө лам хувраг ч байхгүй , уулзах хөгшид ч үгүй болсон.

Гантулга: тухайн үед хэн хаах нураах тухай тушаалыг өгч байсан юм бол?

Цэцэгмаа: Тэр мэлэхгүй .Гэнэт л учир начиргүй хэмхлээд л нураагаад л хачин юм болсон шүү дээ .Бурхан луу аймаар л юм болсон гэдэг. Би мэдэх биш , жоохон байсан.

Гантулга: Хаагдах үед нь та тэрүүгээр явж байв уу, хэдэн настай байсан?

Цэцэгмаа: За би арван хоёр , гуравтай л байсан байх.Би бар жилтэй юм шүү.

Гантулга: Улсууд юу гэж ярьдаг байсан, лам нарыг тэглээ, ингэлээ гээд?

Цэцэгмаа:Аа лам нарыг хамж аваачаад аймаг дээр хийчихлээ гээд , үгүй мөн их гашуудаж хачин байсан.

Гантулга: Аймаг дээр?

Цэцэгмаа: Тийм, аймаг дээр цугийг нь унаа мал , тэмээ эд мал нараар аваад л явна, аваад л явна..Шөнө ч байсан хамаагүй , тэгээд л хамж аваачаад аймагт сүйд хийсэн байх даа

Гантулга: Сүм хийдийн нандин шүтээн ном судрыг яасан бэ?

Цэцэгмаа:Байхгүй. Хамгийг нь шатаачихсан. Хошуу хийдийн ч гэсэн ном юм байхгүй

Гантулга: Сүм хийдийн хаасны дараа ямар зорилгоор ашиглаж байсан бэ?

Цэцэгмаа: Хамгийг нь аймаг руу зөөсөн.Тэгээд хүмүүс л ашиглаж байсан байх даа.

Гантулга: Аа хүмүүс, нутгийнхан. Хашаа хороо байшин барих гэх мэт үү?

Цэцэгмаа: Тийм , малын хороо байшинд л хүмүүс ашиглаж байсан.

Гантулга: Сүм хийдийг сэргээн босгосон уу, суурин дээр нь сэргээн босгосон үү?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Цэцэгмаа: Одоо энэ ерэн оноос л ийм сайхан болсноос биш , урьд нь үгүй.Огт байхгүй.Одооны энэ дарга л юм хийж байгаа.Урьд нь тийм юм огт байхгүй.Хошуу хийдээс ерөөс чимээ,үзсэн харсан юм байхгүй.

Гантулга: Одоо Хошуу хийдийн талаар та нарт хүн хар дээр үлдсэн, таньд үлдсэн зураг энэ тэр байх уу?

Цэцэгмаа: Одоо хийдийн зурмал зураг байдаг шүү дээ.

Гантулга: Хүн хар дээр юм уу, таньд тийм юм байна уу?

Цэцэгмаа:Ерөөсөө байхгүй .

Гантулга: Сүм хийдийг сэргээн босгосон юм бол одоогоор байхгүй юм байна ш дээ ,тиймээ?

Цэцэгмаа: Байхгүй.

Гантулга: Сүм хийдийг нураасны дараагаар одоо ингээд л сүм хийдийг чинь ашиглаад л байшин саванд нь шинээр оёдлын цех ч юмуу, гар урлалын юм байгуулдаг байсан гэж байгаа шүү дээ.Тийм юм дуулж байсан уу, хуучин тэнд чинь суурин газар байсан гэж байгаа ш дээ. Тэгэхээр одоо байшин савыг нь ашиглаад ч гэдэг юм уу, янз бүрийн зорилгоор агуулах сав ч хийдэг юм уу?

Цэцэгмаа: Бараг үгүй байх аа. Нэг мал тууврын бааз байгуулсан гэж нэг дуулдаж байсан .Одоо нэлээн сүүлд шүү дээ. Өшөөгөөр ер нь ашиглаж байсан юмгүй байх

Гантулга: Энэ Хошуу хурал дээр одоо энэ хавь ойрын хошуу хутгийнхан ярьдаг тэр бурхан нь ховор шүү, сайхан шүү гэдэг юм уу, ном судар ч байдаг юм уу, суврага ч байдаг юм уу, тийм бүр нандин.Халхад ховор ч юмуу тийм шүтээн суварга дуулсан очиж үзэж байсан уу, одоо наян тохой майдар , суварга гээд ярьж байсан, түүнийгээ дэлгэрүүлээд яг нүдээр үзэж байсан тухайгаа?

Цэцэгмаа: Наян тохой Майдар гэж үзэж мөргөж явсан даа.Тэгээд нүүрийг нь харж чадаагүй, араас нь өмнөөс нь их хардаг.Тэгээд их л мөргөж сайхан л үзэж явсан даа.

Гантулга: Суумал майдар байсан уу, босоо бурхан байсан уу?

Цэцэгмаа: Босоо л байсан уу, за суумал байсан байх.

Гантулга: Гадуураа дуган байсан уу?

Цэцэгмаа: Дугантай байсан байх.

Гантулга: Цагаан суварга гэж нэг нандин шүтээн яригдаад байна.Тэр талаар ярьж өгөөч?

Цэцэгмаа:Ер очиж үзээгүй. Яахав тийм суварга яригдаад л байдаг байсан.

Гантулга: Сүм хийд нураах үед танай эндхийн хошуу нутаг засаг захиргааны ч юмуу, багийн дарга ч юмуу, ямар улс байсан бэ?

Цэцэгмаа:Сайн мэдэхгүй байна аа.

Гантулга: Та мэдэх үү, Сүм хийд нураах үед чинь одоо бодвол Мандал Овоо гэж сүм байсан юмуу, тэгээд л хүн хар гаргаад л сүм хийдийн чинь байшин савыг тийм юманд зориулна гээд хүн дайчлаад ажилладаг ш дээ.Одоо ингээд л орон нутгаас хүн хар гараад л .Тэр талаар тэдний тэр тийм юманд орж явсан гээд уул нь ярьдаг ш дээ ?

Цэцэгмаа: Ёстой мэдэхгүй юм. Хэн тэгж байсан юм, ямар чиг л байсан нураагаад хэмхлээд л байсан.Нураасан л гэж мэдэхээс өөр юм алга.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Сүм хийдийнх нь эзэн хутагт лам нь тийм том лам байсан гээд дуулсан юм байна уу?

Цэцэгмаа: Үгүй одоо том лам ч байлгүй яахав дээ. Гэсгүй л лав байсан байх. Гэсгүйгээс том лам лав байсан даа.

Гантулга: Тийм хутагт ч гэдэг юм уу, тэр гэдэг нэртэй лам?

Цэцэгмаа: Сайн мэдэхгүй юмаа.

Гантулга: Одоо энэ танай гэрт байгаа сайхан есөн эрдэнийн Жадамба чинь ямар уламжлалтай юм бэ?

Цэцэгмаа: Тэндээс л , Хошуу хийдээс л ирсэн байх. Манай эцгийн эх л залж авсан байх. Бүр манай эцгийг ч төрөхөөс өмнө юм.

Гантулга: Тэгээд нөгөө өөрийнх нь ээж гээд түрүүн дурьдсан байсан , энэ талаар? Яаж бүтээсэн юм?

Цэцэгмаа: Манай эмэг эх Халтар гэж хүн байна. Баян Халтар гэж. Тэр их шүтлэгтэй ном хүн байсан. Тэгээд тэр хүүгээ ч бага насанд нь шавилж суулгаад, тэгээд тэр бурхан шүтээнтэй нэлээн юмтай л айл байсан юм гэнэ лээ. Тэгээд л тэр хувьсгалын үед байхгүй болоод л ...Эн одоо есөн эрдэнийн Жадамбаа л хадгалж үлдсэн юм байдаг юм. Манай ээжид нэлээн сүүлд өгсөн, тэр нас барахаасаа өмнө. Манай эцгийн эх бас л зуу гарч нас барсан. Тэр болтлоо л одоо өөрөө хадгалж явсан судар байдаг юм .Яг хэнээс хаанаас авсныг нь бол мэдэхгүй ээ. Их л олон жил нандигнасан ийм нандин шүтээн дээ.

Гантулга: Ер нь тэр үед дуулж байсан уу, баруун зуу руугаа явж эргэл мөргөл хийдэг ч гэдэг юмуу, эсвэл энэ Барин ламын хийд , Онгийн хийд гээд хүрээгээ өөрөө биеэрээ төөлж яваад, сунаж мөргөж яваад хүрээ ороодог ч гэдэг юм уу тийм юмнууд хүмүүс хийж байсан уу, та өөрөө ч юмуу?

Бархүү: Аа би жаахан байхад нэг явж байсан байх.

Цэцэгмаа: Хадам ээж л их явж байсан хүн дээ, ер нь. Их буянтай хүн байсан юм. Тэр хүн чинь энэ Амаа , Ажаа хоёрыг аваад хаа хүртэл явсан гэдэг билээ... Санахгүй байна аа. Нэг их өвдөөд нэг их том ламд аваачиж, кортсон юмаа даа, ер нь .Ярьдаг байсан даа ээж санадаггүй юм уу даа. Ажаа ,Амаа хоёр их жоохон байсан юм гэнэ лээ. Нээх том лам одоо тээр баруун урагшаа , аль , ямар орон гэлээ

Гантулга: Төвд үү?

Цэцэгмаа: Төвдийн л оронд очиж байсан юм гэнэ лээ. Бүр их жоохон байсан юм гэнэ лээ, ер нь .Тэгээд эдгэж ирж байсан гэж. Тэгээд хоёр , гурван алтан бөгжөө барьж юу яаж байсан гэж...Өргөл өргөж байсан гэж. өргөл өргөхгүй бол буян хурахгүй гэж одоо их л ярьдаг тийм л хүн байсан юм.

Гантулга: Одоо энэ орон хийдийнх нь том лам нар нь одоо лүн бан тавих ч байдаг юм уу, том том ном тавиад л олон түмэн хураад л эргэл мөргөл хийгээд л ийм юмнууд бол байсан уу?

Цэцэгмаа: Хаана тэр вэ?

Гантулга: Хошуу нутагтаа л , одоо та нарыг бага байхад л ?

Цэцэгмаа: Аа одоо ямаршуу юм байсан юм бол...

Гантулга: Одоо Дүйнхорын Ван тавилаа гээд

Бархүү: Аа их болсон

Цэцэгмаа: Айлууд өнөө жас хуруулна гэж яадаг байлаа, ямар?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бархүү: Үгүй ээ тэр одоо жасаа масаа унших...айлууд ч одоо тийм л юм хийлгэдэг байсан

Гантулга: Хүрээн дээр одоо Ван тавих ч гэдэг юм уу, тэр үеэр сүсэгтнүүд их цугладаг ш дээ. Далай лам Ван тавина гэхээр?

Бархүү: Тийм

Гантулга: Тиймэрхүү гаднаас том лам ч юмуу, эсвэл дотроосоо лам нар ч юмуу...?

Бархүү: Ээ тэрийг нь мэдэхгүй юм.

Цэцэгмаа: Тэрийг нь сайн мэдэхгүй юм. Манай эцэг л сайн мэдэх байлаа даа.

Бархүү: Тийм, даанч тэрийг нь би бол сайн мэдэхгүй юм.

Цэцэгмаа: Манай эцэг өөрөө энэ Онгийн Хошуу хийдийн тухай бичиж үлдээсэн юм л даа. Гар бичмэл бичиж, одоо ийм есөн хуудас намтар. Энэ намтраар та бүгдийн одоо асуусан асуултад нэлээн тодорхой байх байх. Үүнийгээ одоо ингээд нэг хувийг нь та бүхэнд өгье

Гантулга: За баярлалаа. Одоо энэ түүхэн баримтыг хойч үедээ үлдээж, бид нарт ингэж залгамжлуулж өгж байгаад их баяртай байна

Цэцэгмаа: За баярлалаа.

Гантулга: За баярлалаа